



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.31 № 01/600
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНЫ ДАРГА
Х.ТАЙВАНБАЯР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (...ж. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт .ж. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛӨХ
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР






ХҮН ТӨВТЭЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
2024-2028 ОН

МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

МӨРӨН ХОТ
2024 он



2024 ОНЫ МӨРӨН СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД
МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ
“ХҮН ТӨВТЭЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР”

Үндэслэл:

- Намын гишүүд дэмжигчдийн өдөрлөгөөс ирүүлсэн санал
- “**Алсын хараа 2050**” МОНГОЛ Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр
- “**ХӨГЖСӨН ХӨВСГӨЛ-2030**” хөтөлбөр
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны УИХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого бүсчилсэн хөгжлийн реформ” мөрийн хөтөлбөр
- **МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030**
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

**Уриа: ТУУШТАЙ СОНГОЛТ
ТУХЛАГ АМЬДРАЛ**

Зорилго: Хүн төвтэй, хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн хангалаун амьдрах, аж ахуйн нэгжийн хөгжих боломжийг дэмжсэн ХӨГЖЛИЙН хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Үр дүн: АМЬДРАЛЫН ЧАНАР
АЯ ТУХТАЙ АМЬДРАЛ
АЮУЛГҮЙ ОРЧИН**

Нэг: ХҮНИЙ ХӨГЖИЛ

1.1Хүүхэд бидний – ИРЭЭДҮЙ

- Зуны цэцэрлэг, Хүүхэд харах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж үргэлжлэх хугацааг уртасган, чанарыг сайжруулахад иргэд, хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.
- ЕБС-иудын Эрүүл мэнд, биеийн тамир, спортын “ГАДНА ЦОГЦОЛБОР ТАЛБАЙ”-г шинэчлэн стандартын дагуу бүрэн тохижуулна.
- Хүүхдийн санал бодлыг бодлого, шийдвэртээ тусгаж эргэж мэдээлдэг журмыг төрийн байгууллагууд хэрэгжүүлнэ.



Мөрөн сум “ХҮҮХДЭЭ СОНСОХ” өдөртэй болж сумын “ХҮҮХДИЙН ЗӨВЛӨЛ”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллана.

- “ХҮҮХДИЙН ӨӨРӨӨ УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН “-ЫН НЭГДСЭН ТӨВИЙГ Мөрөн суманд байгуулна.
- Хүүхэд залуучуудын паркийг үе шаттайгаар бүрэн шинэчилнэ.

1.2 Залуус бидний - ИТГЭЛ

- Аймагт хийгдэж буй томоохон бүтээн байгуулалтын ажилд орон нутгийн залуучуудыг оролцуулж тогтмол ажлын байраар хангана.
- Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй эхний гурван жилд 3 хувийн зээлийн хүүтэй, ИПОТЕКИЙН зээлийн 6 хувийн хүүтэй “МИНИЙ ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ” хөтөлбөрийг хэрэгжүүлж залуу гэр бүлд түрээсээр болон бусад таатай нөхцлөөр орон сууцтай болох боломжийг бий болгоно.
- Мөрөн сумын багуудын дунд спорт тоглоомын талбай бүхий хүүхэд, залуус хөгжлийн төвийг бий болгоно.
- Хөл бөмбөгийн задгай талбайн тохижилтыг сайжруулна.
- Өвлийн спортыг хөгжүүлэх зорилгоор ЦАНЫН БААЗ барихад хувийн хэвшилд дэмжлэг үзүүлнэ.

1.3 Эмэгтэйчүүд бидний -ТҮШИГ

- Эмэгтэйчүүдийн үүсгэл санаачлагын клуб, холбоо ТББ-уудийг бодлогоор дэмжинэ.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл бусад төсөл хөтөлбөрүүдээс санхүүждэг зээл тусlamжийн тодорхой хувийг ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглүүлнэ.

1.4 Ахмадууд бидний - БАХАРХАЛ

Ахмадууд чөлөөт цагаа өнгөрүүлэх, сэргээн засаж чийрэгжүүлэх төвийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулна.

- Ахмад настныг нийтийн тээврээр үнэгүй зорчих эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллана.

1.5 “Баялаг бүтээгчид бидний – ХӨГЖИЛ

Баялаг бүтээгчдээ дэмжих:

- “Баялаг Бүтээгч” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.



- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бүх түвшигд нэмэгдүүлж авилга, хүнд суртлаас ангид, иргэдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээг бий болгоно.
- Төрийн болон төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээр хөнгөлөлтэй зээл, тусlamжинд хамруулна.
- “Хөвсгөл брэнд”-ийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоод, гадаадын зах зээлд гаргах боломж бүрдүүлнэ.


Малчид, тариаланчдаа дэмжих:

- “Залуу Малчин, Тариаланч” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөөгийн залуусаа дэмжинэ.
- Малын гаралтай түүхий эдээр ахуйн түвшинд үйлдвэрлэл эрхлэх төсөл хөтөлбөрийг дэмжинэ.
- Отрын бүс нутгийн судалгааг бодитоор тодорхойлж, Отор, тууврын зам, Отоглох цэгүүдийг байгуулах.
- Max болон сүүн бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, хадгалалт, тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээг бий болгож олон улсын стандартад нийцүүлнэ.
- Малдын хоршоо нөхөрлөлүүдийг чадавхжуулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн төсөл хөтөлбөрт хамруулна.
- Төмс хүнсний ногоо тарих талбай, усан хангамж, хүлэмж, зоорьтой болоход sumaас дэмжих замаар төмс хүнсний ногоогоор Мөрөн сумын хэрэгцээг хангана.

Хоёр: ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНЫ ХӨГЖИЛ

2.1 Ая тухтай орчин - НОГООН ХӨГЖИЛ

- “Хашаандаа тохилог сайхан амьдарцгаая” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ЖИМСНИЙ МОД ТАРИАЛАХ /
 - Дэлгэрмөрөн голын сав дагуу амралт, зугаалгын газрыг тусгайлан байгуулна.
 - Гэрэлтүүлгийг зах, бөглүү газруудад бүрэн хийж, төвийг гэрлэн чимэглэлтэй болгоно.
 - Мөрөн хотыг бүрэн камержуулж “Ногоон бүс” болгоно.
 - Хөршийн холбоог идэвхижүүлж, Олон нийтийн цагдааг ажиллуулна.
 - Нийтийн бие засах, хувцас угаалгын газруудыг байгуулна



“ЦЭМЦГЭР МӨРӨН “хөтөлбөр хэрэгжүүлж хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж дахин боловсруулах ЗR цогц менежментийг хэрэгжүүлнэ.
/хог ангилан ялгах, ландфил шатаах зуух/


2.2 Аж төрөхөд таатай - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

- Мөрөн сумын доторх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангана.
- Том оврын тээврийн хэрэгслийн зогсоол, ачих, буулгах талбай байгуулах.
- “Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангана
- “Зүүн Мөрөн” орон сууцны хороолол, “САЙН ХӨРШ” хаус хорооллыг ашиглалтанд оруулна.
- Мөрөн хотын доторх авто зам дагуух ус зайлцуулах системийг үе шаттай бий болгоно.
- Хувийн хэвшлийн оролцоотой орон сууц, хаус хороолол барих асуудлыг дэмжинэ.
- Захын хорооллуудын гэрэлтүүлгийг бүрэн шийдвэрлэж, хотын төвийг гоёлын гэрэлтүүлэгтэй болгоно.
- Инженерийн шугам сүлжээ бүхий эдэлбэр газартай 6,13 багуудын айл өрхүүдийг дулаан цэвэр усаар бүрэн хангаж, амины орон сууц, нийтийн байр барих санаачлагыг нь дэмжинэ.
- Цаашид боломжтой байрлал бүхий 3 ба 4 дүгээр багуудад Дулаан дамжуулах төвүүдийг барьж төвлөрсөн дулааны шугамд холбоно.
- Дулааны станцын найдвартай ажиллагааг хангаж нийтийн орон сууцуудыг халаалтын улиралд хэрэглээний халуун усаар хангана.
- Гэр хорооллын ЯНДАНГ 30% ЦӨӨЛНӨ.
- Мөрөн хотын Нийтийн тээврийн орон нутгийн оролцоотой аж ахуйн нэгжийг байгуулж, соёл, чанар, хүртээмжтэй стандартыг хангасан үйлчилгээг нэвтрүүлнэ.

ГУРАВ: ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 “Эрүүл Монгол хүн” эрүүл мэндийн үйлчилгээ:

- Мөрөн сумын “Нэгдсэн эмнэлэг” барьж ашиглалтанд оруулна.
- “Иргэн-эрүүл мэнд” явуулын тусlamж үйлчилгээний орон тооны бүтэц бий болгож, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг иргэдэд ойртуулан чанаржуулна.



- Стандартын 6 замтай Фитнес төв бүхий “УСАН БАССЕЙН” шинээр барьж ашиглалтанд оруулна.

- Архигүй Мөрөн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.2 Оюунлаг Хөвсгөлчүүд - Боловсрол, Соёлын үйлчилгээ.

- Мэдээллийн технологид суурилсан “Цахим зайн сургалтын төв”-үүдийг байгуулна.

- “АХЛАХ СУРГУУЛЬ” сургууль хөтөлбөрийг цахим болон танхимиын хэлбэрээр туршин хэрэгжүүлнэ.

“АНГИ УДИРДАГЧ БАГШ” орон нутгийн урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Гадаад хэлний сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулан аялал жуулчлалтай холбож хөгжүүлнэ.

- Нийтийн номын санг цахим хэлбэрт шилжүүлж, орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, хүний нөөцийг чадавхжуулна.

- 800 хүний суудалтай Хөгжмийн драмын театр барина.

- Орон нутгийг судлах музейг орчин үеийн шаардлагад нийцүүлэн дэглэж, 3D технологи бүхий бодит орон зайн системтэй болгоно.

3.3 Зорилтод бүлэгт чиглэсэн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр .

- Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, чанар хүртээмжийг сайжруулан олон талт үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх аргыг боловсронгуй болгож дэмжинэ.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвд суралцах эрхийг хангаж, ажилд ороход нь дэмжлэг үзүүлнэ.

- “Ажилтай иргэн - Амьжиргаатай өрх” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.4 ИРГЭДИЙН ОРОЛЦОО:

- Багийн төвийг ажиллуулан төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулна.
- Бүх түвшний төрийн байгууллагыг цахим болгож үйлчилгээ, мэдээллийг сайжруулна.
- Багийг хүний нөөц, хөрөнгө санхүүгийн хувьд бэхжүүлнэ.
- Иргэнийхээ үүсгэл санаачлагаар байгуулагдсан иргэний нийгмийн байгууллага, холбоо, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.



ДӨРӨВ:ХӨГЖИЛД ХӨТӨЛСӨН ҮЙЛДВЭРЖИЛТ

4.1 Үйлдвэржилт –ХӨГЖЛИЙН БОЛОМЖ

- Орон нутгийн түүхий эдийг ашиглан нэмүү өртөг шингээж импортыг оролсон экспортод чиглэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ
- Орон нутгийн үйлдвэрүүдийг дэмжиж, хөрш аймгууд болон “Хөвсгөлд үйлдвэрлэв” сүлжээ дэлгүүрийг Эрдэнэт, Улаанбаатар хотод байгуулна
- “Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх” сумын хөтөлбөрийг шинэчлэн, хэрэгжилтийг хангана
- Үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлттэй зээлээр дэмжинэ
- Үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээлэл, сургалтын төвийг байгуулна
- Монгол улс, олон улсын үзэсгэлэн худалдаануудад зохион байгуулалттай оролцуулж, бүтээгдэхүүнийг сурталчилна

4.2 Аялал жуулчлал- ХӨГЖЛИЙН ГАРЦ

- Мөрөн суманд жуулчны гудамж төслийг хэрэгжүүлнэ
- Аялалын цахим лавлах гаргана.
- Аялал жуулчлалын гол чиглэлийн зам дагуу ариун цэврийн байгууламж, түр буудаллах, алжаал тайлах цэгүүдийг барьж байгуулан нутгийн иргэдийг ажлын байраар хангана

4.3 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл- ХӨГЖЛИЙН ТУЛГУУР

- Малчдын нэгдэх, хорших үйл ажиллагааг дэмжин “ШИНЭ ХОРШОО” хөдөлгөөнийг өрнүүлж, хоршооллыг дэмжинэ.
- Төмс, хүнсний ногооны хангалтыг 80 хувьд хүргэнэ
- Өндөр хүчин чадал бүхий НОГОО БОЛОВСРУУЛЖ ДАРШЛАХ үйлдвэр байгуулна.
- Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мал амьтны болон байгалийн гаралтай бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж, экспортонд гаргана
 - Сүү, цагаан идээ
 - Ноос, ноолуур боловсруулах
 - Max боловсруулах
 - Сүлжмэл эдлэл
 - Сав баглаа боодол
- Жижиг дунд үйлдвэрийг дэмжинэ



- Эсгий, эсгий эдлэлийн үйлдвэр
- Зоорь, хүлэмжийн аж ахуй үйлдвэр
- Хүнсний ногоо нөөшлөх, даршлах, хатаах үйлдвэр
- Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Мал нядалгааны нэгдсэн цэг, цех

4.4 Байгалийн баялагт түшиглэсэн үйлдвэр - ЭКО ХӨГЖИЛ

- -Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг өргөжүүлэх
- Барилгын материалын үйлдвэр
Түгээмэл тархацтай ашигт малтмал ХАЙРГА, ДАЙРГАНЫ үйлдвэрлэлийг дэмжих
- Ухаалаг, хэмнэлттэй хэрэглээ, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлж дэмжих
- Шахмал түлшний үйлдвэр, мод орлох бүтээгдэхүүн / шахмал түлш / мод боловсруулах
- Жимс, жимсгэнэ
- Чулуун эдлэл
- Тоосго, блок
- Модон эдлэл
- Зөгийний аж ахуй үйлдвэрлэлийг өргөжүүлэх

